



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Матад сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/007/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn Аудитор: С.Энхбаатар Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatarsu@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.24 № 480

танай _____-ны № _____-т

МАТАД СУМЫН ЗАСАГ
ДАРГА Э.САРАНХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Матад сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Матад сумын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас "Хангалтгүй" гэж үнэлж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

011022218

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,866,379.40</u>	<u>2,998,922.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,310,648.70	2,461,456.10
33	АВЛАГА	328,951.60	254,046.30
35	БАРАА МАТЕРИАЛ	226,779.10	283,420.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,031,053.60</u>	<u>7,091,365.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,031,053.60	<u>7,091,365.20</u>
392	Биет хөрөнгө	4,948,083.20	<u>7,008,694.80</u>
393	Биет бус хөрөнгө	82,970.40	82,670.40
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,897,433.00</u>	<u>10,090,287.90</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,897,433.00</u>	<u>10,090,287.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,897,433.00	<u>10,090,287.90</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	897,109.80	897,109.80
512	Хуримтлагдсан үр дүн	5,706,174.00	8,899,176.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	294,149.20	294,001.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,897,433.00</u>	<u>10,090,287.90</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>4,644,432.30</u>	<u>9,567,017.00</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	<u>1,838,599.40</u>	<u>2,488,205.30</u>
110	Орлогын албан татвар	1,555,232.80	2,095,107.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,565,229.30	2,142,314.50
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,996.50	-47,206.70
113	Хөрөнгийн албан татвар	175,114.90	89,873.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	108,251.70	303,224.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	108,251.70	303,224.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>1,763,282.70</u>	<u>3,787,143.80</u>
120	Нийтлэг татварын бус орлого	1,553,282.70	3,103,811.80
122	Тусламжийн орлого	210,000.00	683,332.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,042,550.20</u>	<u>3,291,667.90</u>
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>1,791,408.50</u>	<u>2,737,250.50</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,791,408.50</u>	<u>2,737,250.50</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,385,299.50	2,370,382.20

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590,696.20	905,375.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,959.80	111,957.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,934.00	195,420.90
2104	Хангамж, бараа материалын зардал	52,597.70	75,005.10
2105	Нормативт зардал	556	1,574.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,950.70	50,237.90
2107	Томилолт, зочны зардал	26,188.00	30,693.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,744.10	19,013.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	480,673.00	981,103.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	406,109.00	366,868.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,853,023.80</u>	<u>6,829,766.60</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,053,316.60	3,207,624.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,799,707.20</u>	<u>3,622,142.10</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,191,124.40</u>	<u>6,667,306.40</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	<u>1,838,599.40</u>	<u>2,488,205.30</u>
110	Орлогын албан татвар	1,555,232.80	2,095,107.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,565,229.30	2,142,314.50
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,996.50	-47,206.7
113	Хөрөнгийн албан татвар	175,114.90	89,873.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	108,251.70	303,224.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	967.4	2,659.00
1181	Газрын төлбөр	104,508.00	297,058.70
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,776.30	3,506.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>309,974.80</u>	<u>887,433.20</u>
120	Нийтлэг татварын бус орлого	99,974.80	204,101.20
122	Тусламжийн орлого	210,000.00	683,332.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,042,550.20</u>	<u>3,291,667.90</u>
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,478,286.80</u>	<u>2,245,877.20</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,478,286.80</u>	<u>2,245,877.20</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,096,924.00</u>	<u>1,874,674.70</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590,696.20	905,375.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,959.80	111,957.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,819.50	194,595.40
2104	Хангамж, бараа материалын зардал	47,517.20	53,212.90
2105	Нормативт зардал	840	1,401.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,746.30	47,595.40
2107	Томилолт, зочны зардал	26,188.00	30,693.20

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,490.30	19,013.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	171,666.70	510,485.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	381,362.80	371,202.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,712,837.60</u>	<u>4,421,429.20</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,177,253.90	3,269,121.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,177,253.90	3,269,121.80
2200	Дотоод эх үүсвэрээр	1,177,253.90	3,269,121.80
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,177,253.90</u>	<u>-3,269,121.80</u>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,000.00	0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-50,000.00</u>	<u>0</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	485,583.70	1,152,307.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	825,065.00	1,310,648.60
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,310,648.70	2,461,456.10

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл				
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	850,811.90	294,149.30	3,906,466.60	5,051,427.80
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	46,298.00			46,298.00
C07	Тайлант үеийн үр дүн			1,799,707.10	1,799,707.10
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	897,109.90	294,149.30	5,706,173.70	6,897,432.90
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	897,109.90	294,149.30	5,706,173.70	6,897,432.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-429,139.3	429,139.30
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				6,468,293.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-147.8		-147.8
D08	Тайлант үеийн үр дүн			3,622,142.10	3,622,142.10
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	897,109.90	294,001.30	8,899,176.60	10,090,287.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,465,710.90	5,140,311.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,369,696.50	1,876,574.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,997,810.90	1,804,072.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	970,389.70	905,375.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,886.40	111,957.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,578.10	194,595.40
2104	Хангамж, бараа материалын зардал	58,058.20	53,046.30
2105	Нормативт зардал	1,401.40	1,401.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,539.60	53,324.20
2107	Томилолт, зочны зардал	33,680.00	30,153.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,027.00	19,013.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	536,280.50	435,204.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	371,855.60	72,502.10
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	298,700.40	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,155.20	72,502.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,049,014.40	3,263,736.90
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	47,000.00	0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,465,710.90	6,008,304.90
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,854,261.10	5,235,660.50
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	381,449.80	89,312.40
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	230,000.00	683,332.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	1,004,362.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	1,872,356.10

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 79.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 78.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 0.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор сумын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 78.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан ч тус төсөл, арга хэмжээг 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", Сангийн Сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.4-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон байхаар төлөвлөгөөнд тусгах, төсөвт тодотгол орсон бол төсөв батлагдсан даруйд хэрэгжүүлэхээр тусгана." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

1. Төсвийн орлоготой холбоотой

Илрүүлэлт: Тайлант оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн ч галт зэвсгийн албан татварын төлөвлөгөө 0.3 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Галт зэвсгийн албан татварын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөх.

2. Сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Сумын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас "Хангалтгүй" гэж үнэлж дүгнэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдсан төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй	1	78.9	-	-	1	78.9		
Галт зэвсгийн албан татварын төлөвлөгөө тасарсан.	1	0.3					1	0.3
Сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэгдсэн.	1	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	3	79.2	-	-	1	78.9	2	0.3